

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сагсай сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2025/133/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Өлгий хот
2024 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: Ж.Айгүл

Утас: 70422954 Цахим хаяг: aigulj@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Аудитор: Б.Үүрийнтуяа

Утас: 90832211 Цахим хаяг: uuriintuya.b@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
 3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
 4. Аудитын тайлан
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
 6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



САГСАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН ДАРГА
А.ШЕПЕН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сагсай сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус газар нь 2024 онд 1,191.1 сая төгрөгийн батлагдсан төсвөөр ажиллаж, гүйцэтгэлээр 1,177.6 сая төгрөг зарцуулж, 98.9 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

832502000230

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  ЖАЙГҮЛ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>86,985,110.00</u>	<u>54,847,468.37</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
31110	Төгрөг		
31140	Касс арилжааны банк		
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	-
3121	Төгрөг	-	-
31211	Төрийн сангийн харилцах	-	-
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах		
33	АВЛАГА	100,000.00	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	100,000.00	
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага		
335	Бусад авлага	-	-
3351	Байгууллагаас авах авлага		
3352	Хувь хүмүүсээс авах авлага		
35	БАРАА МАТЕРИАЛ	46,885,110.00	26,851,968.37
354	Хангамжийн материал	46,885,110.00	26,851,968.37
35410	Бичиг хэргийн материал	382,500.00	472,500.00
35420	Аж ахуйн материал	39,702,860.00	26,379,468.37
35440	Түлш, шатах тослох материал	6,799,750.00	
36	НӨӨЦИЙН БАРАА	40,000,000.00	27,995,500.00
36300	Тэжээлийн нөөц	40,000,000.00	27,995,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>4,349,789,190.19</u>	<u>5,169,174,230.24</u>
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,349,789,190.19	5,169,174,230.24
392	Биет хөрөнгө	3,687,448,554.43	4,506,267,166.00
39201	Барилга, байгууламж, орон сууц	937,238,217.00	1,605,427,012.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(80,360,029.94)	(99,140,453.52)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	166,124,793.00	304,844,793.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(99,139,161.17)	(84,122,219.77)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	108,976,540.00	191,346,684.54
39206	Хуримтлагдсан элэгдэл	(52,273,977.67)	(68,557,822.18)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	54,523,659.04	72,730,659.04
39208	Хуримтлагдсан элэгдэл	(21,213,088.18)	(27,026,345.45)
39209	Зам, гүүрийн байгууламж	1,932,419,298.00	1,950,919,298.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(110,957,210.76)	(155,077,316.76)
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,005,058,840.41	1,005,058,840.41

Сагсай сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

39215	Хуримтлагдсан элэгдэл	(152,949,325.30)	(190,135,963.31)
393	Биет бус хөрөнгө	662,340,635.76	662,907,064.24
39301	Програм хангамж	3,436,639.00	4,206,639.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,132,003.24)	(2,335,574.76)
39303	Бусад биет бус хөрөнгө	661,036,000.00	661,036,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл		
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>4,436,774,300.19</u>	<u>5,224,021,698.61</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	4,666,290.00	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4,666,290.00	-
413	Өглөг	4,666,290.00	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	2,036,689.00	
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	2,629,601.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>4,432,108,010.19</u>	<u>5,224,021,698.61</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	4,432,108,010.19	5,224,021,698.61
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,120,116,878.07	1,120,116,878.07
51101	Өмч: - төрийн	1,120,116,878.07	1,120,116,878.07
512	Хуримтлагдсан үр дүн	1,913,075,669.54	2,704,989,357.96
51210	Өмнөх үеийн үр дүн	1,631,259,074.21	1,913,075,669.54
51220	Тайлант үеийн үр дүн	281,816,595.33	791,913,688.42
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,398,915,462.58	1,398,915,462.58
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>4,436,774,300.19</u>	<u>5,224,021,698.61</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,169,930,007.00	2,153,875,163.81
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	304,837,462.00	951,536,742.81
120	Нийтлэг татварын бус орлого	304,837,462.00	951,536,742.81
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	278,647,462.00	911,281,985.54
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	26,190,000.00	40,254,757.27
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	865,092,545.00	1,202,338,421.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	41,188,645.00	19,507,121.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,500,000.00	6,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	25,688,645.00	13,507,121.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	823,903,900.00	1,182,831,300.00

Сагсай сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	823,903,900.00	1,182,831,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	888,113,411.67	1,359,518,769.03
21	УРСГАЛ ЗАРДАЛ	888,113,411.67	1,359,518,769.03
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	816,595,644.67	1,322,236,710.66
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	428,206,856.00	742,431,070.00
210101	Үндсэн цалин	333,303,788.00	427,501,317.00
210102	Нэмэгдэл	83,076,068.00	295,484,753.00
210104	Урамшуулал	11,827,000.00	19,445,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,314,833.00	95,826,800.00
210201	Тэтгэврийн даатгал	34,440,826.62	65,162,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,878,145.57	7,666,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,597,009.47	3,833,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	763,529.19	3,833,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,635,322.15	15,332,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,410,095.00	43,095,514.83
210301	Гэрэл, цахилгаан	622,095.00	1,306,514.83
210302	Түлш, халаалт	21,788,000.00	41,789,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	39,976,077.00	49,863,845.80
210401	Бичиг хэрэг	4,904,450.00	5,938,100.00
210402	Тээвэр, шатахуун	32,528,592.00	42,286,886.80
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,370,935.00	1,638,859.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,172,100.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	582,000.00	1,628,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	27,000.00	
210604	Урсгал засвар	555,000.00	1,628,500.00
2107	Томилолт, зочны зардал	2,300,400.00	4,801,800.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	2,300,400.00	4,801,800.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,851,000.00	15,116.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,790,000.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	28,000.00	
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	
210807	Газрын төлбөр		15,116.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	266,954,383.67	384,574,064.03
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	130,379,168.00	239,645,870.90
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	445,600.00	
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	136,129,615.67	144,928,193.13
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	71,517,767.00	37,282,058.37
2132	Бусад урсгал шилжүүлэг	48,268,200.00	30,900,000.00

Сагсай сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	48,268,200.00	
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		30,900,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	23,249,567.00	6,382,058.37
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	23,249,567.00	6,382,058.37
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-
2200	Дотоод эх үүсвэрээр	-	-
220001	Барилга байгууламж	-	-
221001	Их засвар	-	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>281,816,595.33</u>	<u>794,356,394.78</u>
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	2,442,706.36
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	-
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал-Үндсэн хөрөнгө	-	2,442,706.36
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал-Бараа материал	-	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(2,442,706.36)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>281,816,595.33</u>	<u>791,913,688.42</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>865,092,545.00</u>	<u>1,202,338,421.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	865,092,545.00	1,202,338,421.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	41,188,645.00	19,507,121.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,500,000.00	6,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	25,688,645.00	13,507,121.00
131106	Төсвийн урамшуулал		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	823,903,900.00	1,182,831,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	823,903,900.00	1,182,831,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>749,522,545.00</u>	<u>1,146,864,467.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	749,522,545.00	1,146,864,467.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	678,004,778.00	1,109,582,408.63
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	423,542,200.00	745,113,700.00
210101	Үндсэн цалин	297,741,672.00	429,501,317.00

Сагсай сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210102	Нэмэгдэл	115,618,600.00	296,167,383.00
210104	Урамшуулал	10,181,928.00	19,445,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,942,800.00	95,826,800.00
210201	Тэтгэврийн даатгал	36,001,100.00	65,162,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,235,400.00	7,666,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,388,400.00	3,833,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	847,100.00	3,833,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,470,800.00	15,332,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,913,000.00	43,095,514.83
210301	Гэрэл, цахилгаан	1,125,000.00	1,306,514.83
210302	Түлш, халаалт	21,788,000.00	41,789,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	39,107,210.00	39,906,207.00
210401	Бичиг хэрэг	2,840,000.00	2,856,900.00
210402	Тээвэр, шатахуун	34,239,875.00	34,004,116.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,613,935.00	2,101,391.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		473,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	413,400.00	470,000.00
2105	Нормативт зардал	423,000.00	150,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	423,000.00	150,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,821,795.00	5,710,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	650,795.00	4,623,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	71,000.00	143,200.00
210604	Урсгал засвар	2,100,000.00	944,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,842,400.00	4,941,800.00
210702	Дотоод албан томилолт	2,842,400.00	4,941,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,529,050.00	1,586,016.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	28,584,950.00	671,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	28,000.00	
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	838,000.00	899,800.00
210807	Газрын төлбөр		15,116.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	45,100.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	103,883,323.00	173,251,670.80
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	103,169,323.00	172,189,370.80
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	714,000.00	1,062,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	71,517,767.00	37,282,058.37
2132	Бусад урсгал шилжүүлэг	48,268,200.00	30,900,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	48,268,200.00	

Сагсай сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		30,900,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	23,249,567.00	6,382,058.37
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	23,249,567.00	6,382,058.37
213404	Хөрөнгийн		
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>115,570,000.00</u>	<u>55,473,954.00</u>
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
140001	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
140002	Улсын төсвөөс олгосон зээл		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	115,570,000.00	55,473,954.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	115,570,000.00	55,473,954.00
2200	Дотоод эх үүсвэрээр	115,570,000.00	55,473,954.00
220001	Барилга байгууламж		
221001	Их засвар		
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	115,570,000.00	55,473,954.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(115,570,000.00)</u>	<u>(55,473,954.00)</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	≡	≡
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,120,116,878.07	1,398,915,462.58	1,631,259,074.21	4,150,291,414.86
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,120,116,878.07	1,398,915,462.58	1,631,259,074.21	4,150,291,414.86
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
C07	Тайлант үеийн үр дүн			281,816,595.33	281,816,595.33
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,120,116,878.07	1,398,915,462.58	1,913,075,669.54	4,432,108,010.19
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,120,116,878.07	1,398,915,462.58	1,913,075,669.54	4,432,108,010.19
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,120,116,878.07	1,398,915,462.58	1,913,075,669.54	4,432,108,010.19
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				-
D08	Тайлант үеийн үр дүн			791,913,688.42	791,913,688.42
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,120,116,878.07	1,398,915,462.58	2,704,989,357.96	5,224,021,698.61

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,191,091,700.00	1,177,638,821.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,191,091,700.00	1,177,638,821.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,159,140,700.00	1,146,738,821.63
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	745,113,700.00	745,113,700.00
210101	Үндсэн цалин	409,157,000.00	429,501,317.00
210102	Нэмэгдэл	316,511,700.00	296,167,383.00
210104	Урамшуулал	19,445,000.00	19,445,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	95,826,800.00	95,826,800.00
210201	Тэтгэврийн даатгал	65,162,200.00	65,162,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,666,100.00	7,666,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,833,100.00	3,833,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,833,100.00	3,833,100.00

Сагсай сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210205	Эрүүл мэндийн даатгал	15,332,300.00	15,332,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,289,900.00	43,095,514.83
210301	Гэрэл, цахилгаан	2,000,000.00	1,306,514.83
210302	Түлш, халаалт	41,289,900.00	41,789,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	39,547,800.00	37,919,291.00
210401	Бичиг хэрэг	3,082,000.00	3,705,600.00
210402	Тээвэр, шатахуун	30,942,300.00	30,942,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,353,500.00	2,101,391.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	700,000.00	700,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	470,000.00	470,000.00
2105	Нормативт зардал	700,000.00	150,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	700,000.00	150,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	27,886,600.00	27,866,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	11,243,400.00	11,223,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	143,200.00	143,200.00
210604	Урсгал засвар	16,500,000.00	16,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	6,100,000.00	4,941,800.00
210702	Дотоод албан томилолт	6,100,000.00	4,941,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,436,900.00	1,586,016.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,072,900.00	671,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	513,000.00	
210803	Даатгалын үйлчилгээ	184,800.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	392,000.00	
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	120,400.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	981,000.00	899,800.00
210807	Газрын төлбөр	128,500.00	15,116.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	44,300.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	190,239,000.00	190,238,999.80
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	189,176,700.00	189,176,699.80
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,062,300.00	1,062,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,951,000.00	30,900,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	31,951,000.00	30,900,000.00
213208	Хөдөө орон нутаг тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	30,900,000.00	30,900,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,051,000.00	
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-
2200	Дотоод эх үүсвэрээр	-	-
220001	Барилга байгууламж		
221001	Их засвар		

Сагсай сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,191,091,700.00	1,177,638,821.63
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,191,091,700.00	1,177,638,821.63
132001	Орон нутгийн төсвөөс	1,191,091,700.00	1,177,638,821.63
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	26	27
620001	Удирдах ажилтан	10	10
620002	Гүйцэтгэх ажилтан	9	9
620003	Үйлчлэх ажилтан	3	4
620004	Гэрээт ажилтан	4	4
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	26	27
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	9	9
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	4	5
650010	Гэрээт ажилтан	4	4
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	9	9

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	41,188,645.00	19,507,121.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	41,188,645.00	19,507,121.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	37,827,970.00	18,317,541.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,135,705.00	2,835,616.00
210402	Тээвэр, шатахуун	1,135,705.00	2,835,616.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	36,692,265.00	15,481,925.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	36,692,265.00	15,481,925.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,360,675.00	1,189,580.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	3,360,675.00	1,189,580.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-
2200	Дотоод эх үүсвэрээр	-	-

220001	Барилга байгууламж		
221001	Их засвар		
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	41,188,645.00	19,507,121.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	41,188,645.00	19,507,121.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,500,000.00	6,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	25,688,645.00	13,507,121.00
131106	Төсвийн урамшуулал		
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Сагсай сумын Засаг даргын тамгын газар нь эдийн засаг, нийгмийн асуудлаар бие даан шийдвэр гаргах, төрийн бодлого, хууль тогтоомжийн биелэлтийг хэрэгжүүлэх, иргэдэд үзүүлэх засаг захиргааны болон нийгмийн үйлчилгээг зохион байгуулах, хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага юм.

Сагсай сумын Засаг даргын тамгын газар нь 2023 онд “Хөрөнгө оруулалтыг сумын хөгжилтэй уялдуулах замаар ард түмний санал санаачилгад тулгуурлан хэрэгжүүлснээр нийгэм, эдийн засгийн хөгжлийг хурдасгаж, аймгийн Загвар сум болгох” зорилго дэвшүүлжээ.

Дээрх зорилтын хүрээнд доорх дэд зорилтуудыг хэрэгжүүлэхээр тусгасан байна. Үүнд:

- I. Сумын нийгэм, эдийн засгийн хөгжил, боловсрол, эрүүл мэнд, соёлын салбарын хүрэх түвшин тодорхойлох, иргэн бүр эрүүл, боловсролтой, орлоготой, амьжиргааны чадавхтай болгох.
- II. Байгалийн баялаг, түүхий эдэд тулгуурлан хөгжлийг бий болгох
- III. Ард иргэдийн үүсгэл санаачилгыг дэмжиж ажлын байр бий болгох

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Сагсай сумын Засаг даргын тамгын газар нь Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Сагсай сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

Засгийн газрын 2024 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 128 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн сүлжээнд үнэмлэхгүй хэмжээний өөрчлөлт орсон.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь тус аймгийн төсөвт байгууллагуудын санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага юм. Тус албанаас 2024 онд Сагсай сумын Засаг даргын тамгын газарт хяналт шалгалт хийгдсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сагсай сумын Засаг даргын тамгын газар нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Сагсай сумын Засаг даргын тамгын газрын даргын 2019 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн Б/08 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад *нийцсэн*, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт *тохирсон* байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сагсай сумын Засаг даргын тамгын газар нь 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 787.3 сая төгрөгөөр буюу 17.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт /мянган төгрөгөөр/
Б	1.00	2.00	3=2-1
Мөнгөн хөрөнгө		-	-
Авлага	100.00	-	-
Урьдчилж гарсан зардал			-
Бараа материал	46,885.11	26,851.97	(20,033.14)
Нөөцийн бараа	40,000.00	27,995.50	(12,004.50)
Үндсэн хөрөнгө	4,349,789.19	5,169,174.23	819,385.04
Нийт хөрөнгө	<u>4,436,674.30</u>	<u>5,224,021.70</u>	<u>787,347.40</u>
Өр төлбөр	4,666.29	-	(4,666.29)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	4,432,108.01	5,224,021.70	791,913.69
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	<u>4,436,774.30</u>	<u>5,224,021.70</u>	<u>787,247.40</u>

Эх сурвалж: Аудитын судалгаа

Мөнгөн хөрөнгө, урьдчилж гарсан зардал дансдад өөрчлөлт ороогүй, авлага, бараа материал, нөөцийн бараа, үндсэн хөрөнгө, өр төлбөр засгийн газрын хувь оролцоо дансдад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Бараа материалын данс 20.0 сая төгрөгөөр буурсан нь сумын ОНХС-гийн хөрөнгөөр бэлтгэсэн нөөцийн өвс тэжээлээс зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс 819.4 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 55.5 сая төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан 911.3 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, үндсэн хөрөнгөнд 144.9 сая төгрөгийн элэгдэл байгуулж, элэгдлээ бүрэн нөхөөгүй 40.0 сая төгрөгийн авто тээврийн хэрэгслийгаймгийн ИТХ-ын 2024 оны 272 дугаар тогтоолоор аймгийн Цагдаагийн газрын балансад шилжүүлж нийт дүнгээр өссөн байна.

Засгийн газрын хувь оролцоо данс тайлант онд 791.9 сая төгрөгийн үр дүнтэй 791.9 сая төгрөгөөр өссөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус газрын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг Орон нутгийн төсвөөс 1245.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас төсвийг хянаж орон нутгийн төсвөөс санхүүжих төсвийг 1,191.1 төгрөгөөр баталсан байна. Төсвийн төслөөс илүү байгаа нь 2024 онд цалин хөлс,

орон нутгийн нэмэгдэл цалин нэмэгдсэнтэй холбоотой зардлыг тодотгож өгсөнтэй холбоотой илүү байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөвт тодотгол хийгдээгүй байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 1,119.7 сая төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,177.6 сая төгрөгийн санхүүжилтийг авч, 5.2 сая төгрөгийг орон нутагт төвлөрүүлж, 8.3 сая төгрөгийн дутуу санхүүжилт авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,177.6 сая төгрөг буюу 98.9 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-70106					
1	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	882,862.10	879,236.00	3,626.10	99.6
2	80102-Туслах үйл ажиллагааны зардал	235,069.20	233,502.82	1,566.38	99.3
3	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж	31,951.00	30,900.00	1,051.00	96.7
4	81102-Орон нутгийн нөөц хөрөнгө	34,000.00	34,000.00	0.00	100.0
5	81701-Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	7,209.40		7,209.40	0.0
	Дүн	1,191,091.70	1,177,638.82	13,452.88	98.9

Эх сурвалж: Аудитын судалгаа

Үндсэн үйл ажиллагааны хөтөлбөрөөс 3.6 сая төгрөгийг, туслах үйл ажиллагааны хөтөлбөрөөс 1.6 сая төгрөгийг, ажил олгогчоос олгох тэтгэмжийн зардлаас 1.1 сая төгрөг, байгаль хамгаалах, нөхөн сэргээх хөтөлбөрөөс 7.2 сая төгрөгийн нийтдээ 13.5 сая төгрөгөөр бага гүйцэтгэлтэй байгаа нь төсвийн төлөвлөлт үндэслэлгүй байгаатай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлийн судалгааны дүн дараах байдалтай байна. Үүнд:

Сагсай сумын Засаг даргын тамгын газар нь ахмадын сан байгуулаагүй, худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж ажиллаагүй байна.

Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлаас 0.7 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлын дансаар 188.1 сая төгрөгийг зарцуулсан байна.

Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн /210801/ төсвөөс 0.7 сая төгрөгийг, бараа үйлчилгээний бусад зардлын /210901/ төсвөөс 188.1 сая төгрөгийг зарцуулсан байна.

Тус байгууллагад 2024 онд 26 орон тоо батлагдсанаас гүйцэтгэлээр удирдах ажилтан 10, гүйцэтгэх ажилтан 9, үйлчлэх ажилтан 8, нийтдээ 27 орон тоогоор батлагдсан орон тооноос 1 орон тоо илүү, төсөвт багтаан ажилласан байна

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сагсай сумын Засаг даргын тамгын газар нь ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөр 6.0 сая, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 13.5 сая төгрөгийн нийтдээ 19.5 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч, хангамж, бараа материалын зардалд 2.8 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 15.5 сая төгрөгийг хамруулан зарцуулж, оны эцэст 1.2 сая төгрөгийн орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Засаг даргын тамгын газар нь 2024 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Батлагдсан төсвийн хүрээнд 83.4 сая төгрөгийн бараа материал, 55.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сагсай сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Үүрийнтуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Сагсай сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайланг 2025 оны 1 дүгээр сарын 24-ны өдрийн 03/31 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Сагсай сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 888.1 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 13.3 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах асуудлын хүрээнд тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 33 шалгуур үзүүлэлтээр горим сорил хэрэгжүүлсэн. Батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулсан ба алдаа, зөрчил илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБООУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны хэрэгжилтийг шалгаж үзэхэд оны эхэнд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө баталж, мэдээлээгүй, худалдан авалттай холбоотой таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг хэсэгт 10 гүйлгээний мэдээллийг мэдээлээгүй. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 98.7 хувьтай байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сагсай сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1.1 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосныг барагдуулж ажилласан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Санхүүгийн тайлангийн аудитын цаг хугацааны хязгаарлалттай байдалтай холбоотой санхүүгийн тайлагнал, санхүүгийн баримтыг түүврийн аргаар эрсдэлд тооцож үзсэн тул цалин хөлсний олголт, НДШ-ийн ногдуулалтын тооцоолол, бусад зардал, авлага, өглөг, бараа материалын зарцуулалтыг бүрэн шалгах боломжгүй тул эрсдэлтэй гэж сонгосон данс, ажил гүйлгээнүүдэд горим сорил хэрэгжүүлсэн. Төсвийн гүйцэтгэлийн зарцуулалтыг үзэх шаардлагатай.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 47.7 сая төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад санхүүгийн тайланд 47.7 сая төгрөгийн алдааг залрууллаа. Залруулсан алдаа:

- Мөнгөн гүйлгээний тайлан, үндсэн хөрөнгийн тодруулгын тайланд төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 17.9 сая төгрөгийн хөрөнгийг зөрүүтэй тайлагнасан.
- Санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй авсан 12.3 сая төгрөгийн бараа материалыг дутуу тайлагнасан.
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд санхүүжүүлэх эх үүсвэр, зарлагын гүйцэтгэлийн батлагдсан төсвийг 16.5 сая төгрөгөөр дутуу, урсгал санхүүжилтийг 1.1 сая төгрөгөөр илүү тайлагнасан.

Энэ нь Сангийн сайдын 2012 оны 76 дугаар тушаалаар баталсан “Төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргах журам”, 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам, УСНББОУС 1 стандарт, толилуулга гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 80.4 сая төгрөгийн зөрчил илэрч 4.9 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 75.5 сая төгрөгийн зөрчил зөвлөмж өгөгдсөн.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар 4.9 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

1. Сумын Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн Б/02 дугаар захирамжаар 2 албан хаагчид, сумын Засаг даргын тамгын газрын даргын 2024 оны 04 дүгээр сарын 12-ний өдрийн Б/05 дугаар тушаалаар 2 албан хаагчид хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдад 5 жил тутам нэг удаа олгох мөнгөн урамшууллын тооцоогоор 4 албан хаагчид нийт 27.9 сая төгрөгийн мөнгөн урамшуулал олгохдоо 2.9 сая төгрөгийн хувь хүний орлогын албан татвар суутгаагүй олгосон байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Татварын хууль тогтоомжид хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно”, 6.1.19-д “суутган төлөгч” гэж тухайн төрлийн татварын хуулийн дагуу татвар төлөгчийн төлөх татварыг суутгаж, төсөвт шилжүүлэх, тайлагнах үүрэг бүхий этгээдийг”, 28 дугаар зүйлийн 28.7-д “Суутган төлөгч нь татварын хууль тогтоомжийн дагуу тухайн төрлийн татвар төлөх үүрэг бүхий этгээдээс албан татварыг ногдуулан суутгана.”,

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д “Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно”, 6.3.1-д “цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого”, 21-р зүйлийн 21.1-д “Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасны дагуу тухайн жилийн орлогыг тодорхойлоход 0-120 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 10 хувиар,..... тооцон албан татвар ногдуулна”, 25 дугаар зүйлийн 25.1-д “Энэ хуулийн 4.1.11-д заасан суутган төлөгч албан татвар ногдуулахад доор дурдсан журмыг баримтална”, 25.1.1-д “энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөр барагдуулах акт тогтоов.

2. Албан хаагчдад тайлант онд олгосон урьдчилгаанаас 2024 оны 1 дүгээр сард 1 албан хаагчид олгосон 2.0 сая төгрөгийн урьдчилгааг суутгаж аваагүй, санхүүгийн тайланд авлагаар тусгаж тайлагнаагүй орхигдуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8-т “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 16 дугаар зүйлийн 16.5-д “Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 26 дугаар зүйлийн 26.1-д “Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккрузл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө”,

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 -д “Үнэн зөв байх”, 14 дүгээр зүйлийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2-т “14.4.2. бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөр барагдуулах акт тогтоосон.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөгдөөгүй.

5.3 Зөвлөмж

Аудитаар 75.5 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгөв.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

1. Оны эцэст цалингийн зардлаас 0.7 сая төгрөгийг шатахууны зардалд эдийн засгийн ангилал зөрчиж зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалт, Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал”-ыг зөрчсөн байна.

1.1 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврыг мөрдөж, батлагдсан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байдлаар төлөвлөж зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

2. Шилэн дансны хууль тогтоомж, худалдан авах ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилттэй холбоотой асуудал

1.2 Илрүүлэлт:

Тайлант оны шилэн дансны веб сайтын мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгаж үзэхэд оны эхэнд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө баталж, мэдээлээгүй, худалдан авалттай холбоотой таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг хэсэгт 10 гүйлгээний 75.5 сая төгрөгийн санхүүжилтийн мэдээллийг мэдээлээгүй. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 98.7 хувьтай байна.

Шилэн дансанд байршуулах төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 2.3 сая төгрөгийн 3 шийдвэрийг байршуулаагүй, оны эхэнд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө баталж, мэдээлээгүй,

өмнөх оны аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг оруулаагүй шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилт 93.7 хувьтай байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална.....”, 6 дугаар зүйлийн 6.1, 6.1.1, 6.4, 6.4.8 дахь заалтуудтай нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална.....”, 6 дугаар зүйлийн 6.1-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”, 6.1.1-т “тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор” 6.4-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ....”, 6.4.8-д “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” заасны дагуу мэдээллийг хугацаанд мэдээлж ажиллах, өмч, хөрөнгө зарцуулсан тушаалыг шилэн дансанд нөхөж байршуулах.

Дээрх зөвлөмж болон бусад шийдвэрийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
Мөнгөн гүйлгээний тайлан, үндсэн хөрөнгийн тодруулгын тайланд төсвийн хөрөнгөөр худалдаж авсан хөрөнгийг зөрүүтэй, үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй авсан бараа материалыг дутуу тайлагнасан.	1	30,111.2			1	30,111.2	1	30,111.2				
Төсвийн гүйцэтгэлийн тайланд санхүүжүүлэх	1	17,551.0			1	17,551.0	1	17,551.0				

Сагсай сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

эх үүсвэр, зарлагын гүйцэтгэлийн батлагдсан төсвийг зөрүүтэй тайлагнасан.												
Дүн	1	47,662.2			1	47,662.2	1	47,662.2				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Мөнгөн урамшууллаас хувь хүний орлогын албан татварыг суутгаагүй олгосон.	1	2,917.3	1	2,917.3								
Суутгаагүй урьдчилгааг санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй	1	2,000.0	1	2,000.0								
Зардлын ангилал зөрчиж цалингийн зардлаас шатахуунд зарцуулсан.	1	682.6					1	682.6				
Дүн	1	5,599.9	1	4,917.3			1	682.6				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Тайлант оны оны эхэнд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө баталж оруулаагүй,, худалдан авалттай холбоотой таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтыг мэдээлээгүй.	1	75,510.0					1	75,510.0
Дүн	1	75,510.0					1	75,510.0
Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	1	75,510.0					1	75,510.0